



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/123/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2020 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	11
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.27 № 1-6/122
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010020091

Аудитын гол асуудал

- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн орон тоог 269 өөр баталсан бөгөөд 2019 онд 291 ажилтан ажиллуулж 22 орон тоо хэтрүүлсэн байна. Батлагдсан орон тоо хэтрүүлснээс цалингийн сан 131,790.0 хэтэрч үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тайланд материаллаг байдлын түвшинг 95,711.7 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн үе шатанд илэрсэн зөрчил нь 131,790.0 мянган төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 36,078.3 мянган төгрөгөөр давсан байна.

Үүрэг, хариуцлага

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Баярмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 18-нээс 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь **Шилдэг технологи, нотолгоонд тулгуурласан оношилгоо, эмчилгээ, сувилгааны цогц үйлчилгээг таатай орчинд ур чадвар, ёс зүй, харьцаа хандлагыг эрхэмлэсэн хүний нөөцөөр үзүүлэхэд** оршино.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь

- *Хүн ам ялангуяа эх хүүхэд, ядуу эмзэг бүлгийн иргэдэд хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хамралт ашиглалтыг нэмэгдүүлэх*
- Эм зүй ба дэмжих үйлчилгээ
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар
- Эрүүл мэндийн санхүүжилт
- Хүний нөөцийн хөгжил
- Зан үйлийн өөрчлөлт ба харилцаа гэсэн үндсэн 6 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- МУЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж 2, 3, 5, 6, 7 дугаар хавсралтуудаар нэмэгдэл олгож эхэлсэн. Тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлагдаагүй тул ур чадварын нэмэгдэл олгоогүй.
- Журам батлах тухай МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгож эхэлсэн.
- “Журам батлах тухай” МУЗГ-ын 2019 оны 6 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай МУЗГ-ын 2019 оны 24 дүгээр тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалыг мөрдөж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилолтын зардлын шинэчлэн тогтоосон хэмжээг мөрдөж эхэлсэн.
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журамын тушаал шинэчлэгдэж Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал батлагдсаныг мөрдөн ажиллаж байна. Энэ тушаалаар Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаал хүчингүй болсон.
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын орон нутгийн төвийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад хоол, унааны хөнгөлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг өдөрт 3,000 төгрөгөөр тогтоосныг мөрдөж ажилласан.
- Эрүүл мэндийн сайдын худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах тухай Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалыг үндэслэн хуучин мөрдөж байсан тушаалыг шинэчлэн боловсруулж 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны А/34 дүгээр тушаалыг мөрдөж эхэлсэн.
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А293 дугаар тушаалыг үндэслэн төлбөртэй тусламж үйлчилгээний тарифт өөрчлөлт оруулан хуучин мөрдөж байсан тушаалыг шинэчлэн боловсруулж 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны А/36 дугаар тушаалыг мөрдөж эхэлсэн.

2.5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд асoлуoс программ хангамж ашигладаг байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитаар Аймгийн Нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны эхний хагас жилийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 9,426,142.6 мянган төгрөгөөс тооцон 94,261.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 95,711.7 мянган төгрөгөөр тооцсон нь цэвэр хөрөнгийн 1 хувиар тооцсонтой холбоотой болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,093.5 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,018.7	324.7	-624.0
Авлага	37,153.0	36,696.9	-456.1
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	472,962.6	448,263.2	-24,699.4
Үндсэн хөрөнгө	8,403,579.8	9,522,878.5	1,119,298.7
Нийт хөрөнгө	8,914,714.1	10,008,163.3	1,093,449.2
Өр төлбөр	379.9	436,995.3	436,615.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,914,334.1	9,571,167.9	656,833.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,914,714.1	10,008,163.3	1,093,449.2

Авлага дансны үлдэгдэл /буурсан/ нь оны эхний авлагын 80.9%-аар бууруулсан. Авлага дансны үлдэгдэлд 2012, 2018 онуудад үүссэн, он удаан жил болсон 600.0 мянган төгрөгийн байгууллагаас авах, хувь хүнээс авах 4,896.9 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс он удаан жил болсон, төлөх боломжгүй шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 4,896.9 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь барагдуулах боломжгүй авлага тайланд тусгагдаж он удаан жил болсон, тайлангийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Бараа материалын дансны нийт үлдэгдэл 448.3 сая төгрөг, үүнээс нярвын агуулахад бүртгэлтэй байгаа хөрөнгө 118.7 сая төгрөг буюу нийт үлдэгдлийн 26.5%-тай байна. Үүнээс эм эмнэлгийн хэрэгсэл 68.9 сая /58.0%/ төгрөг, аж ахуйн материал 45.1 сая /38.1%/ төгрөг, бичиг хэрэг 2.0 сая /1.6%/ төгрөг, шатахуун 0.9 сая /0.8%/ төгрөг, сэлбэг 0.2 сая /0.2%/ төгрөг, хүнсний материал 1.5 сая /1.3%/ төгрөг байна. Энэ нь дараагийн төсвийн жилийн санхүүжилт эхэлтэл тусламж үйлчилгээний тасралтгүй бэлэн байдлыг хангах, төрийн үйлчилгээг ард иргэдэд саадгүй хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагаар тодорхойлогдоно. Мөн болзошгүй гамшгийн бэлэн байдлыг хангахад эм хэрэгсэл, бараа материалын нэг сарын нөөцтэй байх шаардлагатай гэж үздэг.

Бараа материалын дансны нийт үлдэгдэл өмнөх оноос 24.7 сая төгрөгөөр буурсан нь эм боох материал, шатахуун тослох материал, хүнсний материалын оны эцсийн үлдэгдэл 222.5-59,156.9 мянган төгрөгөөр буурсан нь шалтгаалсан.

Бараа материалын дансанд хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгө байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 13.9 тэрбум төгрөг байсан. Тайлант жилд шинээр 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 191.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлагдаж данснаас хасагдсан.

Төсвийн хөрөнгөөр 22.7 сая төгрөгийн, оны эхний авлага барагдуулж 10.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтаар 278.6 сая төгрөгийн, төсөл хөтөлбөрөөр 1,776.6 сая төгрөгийн, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 243.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 184.0 сая төгрөгийн, балансаас балансад шилжүүлэн хүлээн авсан 19.1 сая төгрөгийн, байгууллага дотооддоо 2.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох баримт шийдвэрийг үндэслэн орлого авч бүртгэн эд хариуцагчид хариуцуулан бүртгэсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 74 дүгээр тогтоолоор 17.1 сая төгрөгийн автомашин, 165.6 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 8.7 сая төгрөгийн тавилга эд хогшил акталж данснаас хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оны жилийн эцсийн дүнгээс 436.6 сая төгрөгөөр өссөн нь ажил олгогчийн НДШ, тогтмол зардлуудад тухайн онд шинээр өр үүссэн, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад зориулан эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авснаас шалтгаалсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,571.2 сая төгрөг болж 656.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 8,607.1 мянган төгрөгийн бичилт нь ашиглалтаас хассан үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 155,111.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 293,419.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 189.2% хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төлбөртэй тусламж үйлчилгээний орлого	155,111.5	293,419.5	138,308.0	189.2
Нийт дүн	155,111.5	293,419.5	138,308.0	189.2

Төлбөртэй тусламж үйлчилгээний орлого 138,308.0 мянган төгрөгөөр давсан нь төлбөртэй тусламж үйлчилгээний орлогын тарифт өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 6,650,380.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 6,645,300.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 5,080.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 3,271,334.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,223,934.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 155,111.5 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 1.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,648,495.1 мянган төгрөг буюу 99,97% хувьтай байгаа нь батлагдсан санхүүжилт, орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг зардлын зүйлийн дагуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Аймгийн ИТХ-ын даргын 2019 оны захирамжаар цусны донорын өдөр, 20 ортой эмнэлгийн тохижилтод зориулсан санхүүгийн дэмжлэгээр 2,000. мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2019 оны А/568 дугаар захирамжаар “Говийн чоно-2019” гамшгаас хамгаалах олон улсын сургалт дадлагын санхүүгийн дэмжлэгээр 6,510.0 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийн орлогоор ЭМДЕГазраас санхүүжсэн 19,772.0 мянган төгрөг, элэгний В,С вирус илрүүлэг баталгаажуулах шинжилгээний санхүүжилтээр ЭМДЕГазраас санхүүжсэн 4,164.5 мянган төгрөг, батлагдсан төсвийн хүрээнд нээлттэй зарласан тендерийн баримт бичгийн төлбөрт ТӨБЗГазраас 396.0 мянган төгрөг, гемодиализ эмчилгээний өрөөний урсгал засварын зардалд “Ачир”ХХК-с хандивласан 2,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос Сангийн сайдын тушаалаар нэмэлт орлогоор бүртгэсэн 135,814.4 мянган төгрөг, өмнөх оны

төвлөрүүлсэн үлдэгдлийг Сангийн яамнаас буцаан олгосон 379.9 мянган төгрөг, нийт 171,507.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нэмэгдэл урамшуулал, АОНДШ-д 131,790.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 10,473.5 мянган төгрөг, нормативт зардалд 3,604.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 22,054.2 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардалд 3,085.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 500.0 мянган төгрөг, нийт 171,507.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 847,351.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 605480.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 241,871.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 605,480.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 онд Халаалтын зардалд-94,041.9 мянган төгрөг, Цэвэр,бохир усны төлбөрт-49,281.6 мянган төгрөг НДШ-ийн зардалд 12,047.4 мянган төгрөг, Эм, эмнэлгийн хэрэгсэлд 281,622.7 мянган төгрөг нийт 436,993.6 мянган төгрөгийн өглөг үүсгэж батлагдсан төсөв хэтрүүлсэн байна.
Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны төсвийн төсөөллийг авч үзэхэд:
 - Халаалтын зардалд 530,462.3 мянган төгрөг, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнд 204,032.3 мянган төгрөг нийт 734,494.6 мянган төгрөгөөр тооцоолсон байна. ЭМЯамнаас төсвийг хянаж батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн 550,544.6 мянган төгрөгөөр баталсан боловч дулааны үнэ өссөнөөс шалтгаалан 94,041.9 мянган төгрөгийн дулааны өр үүссэн байна.
 - Цэвэр бохир усны зардлыг 191,458.1 мянган төгрөгөөр, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнд 110,183.3 мянган төгрөг нийт 301,641.4 мянган төгрөгөөр тооцоолсон байна. 2019 оны төсвийг 121,507.5 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 29,282.8 мянган төгрөгөөр бууруулж баталснаас 49,281.6 мянган төгрөгийн өр үүссэн байна.
 - Эмийн зардалд 1,388,775.9 мянган төгрөгөөр төсвийн төсөөлөл хийсэн. Харин 2019 онд эмийн зардлыг 1,286,899.7 мянган төгрөгөөр баталсан нь урьд оны төлөвлөгөө гүйцэтгэлээс 126,817.6 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь 281,622.7 мянган төгрөгийн өр үүссэн байна.
 - Орон тоог 287 төлөвлөж, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнд 60 нийт 347 орон тоогоор төсвийн төсөөллөө тооцоолсноос 269 орон тоо батлагдсан байна. Батлагдсан орон тоог 22-оор хэтрүүлснээс цалингийн зардал хэтэрч 131,790.0 мянган төгрөгөөр хэтрүүлж 12,047.4 мянган төгрөгийн өр үүссэн байна.

2019 онд 436,993.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалт, нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлыг батлагдсан төсөвт багтаан өр төлбөр үүсгэхгүй байх талаар албан шаардлага өгөх.

2. Тайлант хугацаанд 36,696.8 мянган төгрөгийн авлагатай гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага үүсгэхгүй байх тухай албан шаардлага өгөх

3. Тайлант онд 269 орон тоо батлагдсанаас 291 ажилтан ажилласан байна. Орон тооны хэтрэлтээс шалтгаалан цалингийн зардал болон НДШ-ийн зардалд 131,790.0 мянган төгрөг нэмэлтээс гаргасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан цалингийн сан орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо ажилчдын цалинг тогтоох тухай албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 241,871.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь ЭМДСангаас санхүүжих орлогыг тайлант онд орлогоор бүртгэдэггүй зөвхөн төсвийн гүйцэтгэлээр бүртгэж, батлагдсан орлогын санхүүжилтээс давсан орлогыг дараа онд нэхэмжилж орлогоор бүртгэдэг байна. Иймээс тайлант оны үр дүн буруу илэрхийлэгдэж байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 150 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос 3.8 сая төгрөгийг барагдуулсан, 52.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 52.1 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 11,5 сая төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлттэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт: АЗД-ын 2018оны А/169, А/267, Аймгийн ЭМГазрын даргын 2019 оны А/18, А/38, А/48, А/47 тушаалаар эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерт шалгарсан компаниудаас худалдан авалт хийхдээ гэрээний үнийн дүнг 241,871.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Эм эмнэлгийн хэрэгслийн зардал 2018 онд 1,413,717.3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэл 1,413,717.3 мянган төгрөг байсан. Харин 2019 онд 126,817.6 мянган төгрөгөөр бууруулж 1.286.899,7 мянган төгрөг баталсан байна.*

Энэ нь гэрээний дүн болон төсвийн гүйцэтгэл хэтрэхэд нөлөөлжээ.

1.2. Эрсдэл: Батлагдсан төсөв хэтрэх, үр ашиггүй зардал гарах

Өгссөн зөвлөмж: *Төсвийн тухай хуулийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсний дагуу гэрээний дүнгээр худалдан авалт хийж байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>511,134,292.98</u>	<u>485,284,783.41</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,018,750.00	324,750.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,018,750.00	324,750.00
3121	Төгрөг	1,018,750.00	324,750.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,018,750.00	324,750.00
33	АВЛАГА	37,152,991.69	36,696,853.00
335	Бусад авлага	37,152,991.69	36,696,853.00
3351	Байгууллагаас авах авлага	28,369,733.69	27,327,011.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,783,258.00	9,369,842.00
35	БАРАА МАТЕРИАЛ	472,962,551.29	448,263,180.41
351	Түүхий эд материал	220,379,202.46	161,222,306.21
35130	Эм боох материал	220,379,202.46	161,222,306.21
354	Хангамжийн материал	252,583,348.83	287,040,874.20
35410	Бичиг хэргийн материал	2,853,217.00	3,425,559.40
35420	Аж ахуйн материал	243,619,660.35	275,130,817.06
35430	Сэлбэг хэрэгсэл	1,805,700.00	5,250,500.00
35440	Түлш, шатах тослох материал	2,594,634.48	1,746,349.74
35460	Хүнсний материал	1,710,137.00	1,487,648.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,403,579,756.91</u>	<u>9,522,878,520.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,403,579,756.91	9,522,878,520.12
392	Биет хөрөнгө	7,858,547,256.91	8,977,276,540.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,090,821,470.00	6,398,230,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,992,035.19	-242,722,153.35
39203	Авто-тээврийн хэрэгсэл	373,015,320.00	357,390,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-236,768,378.71	-265,106,147.53
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,592,707,712.89	8,558,636,605.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,050,114,057.96	-5,996,555,210.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	270,131,299.37	357,719,436.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	-176,738,605.49	-191,853,121.50
39217	Ном	1,484,532.00	1,536,332.00
393	Биет бус хөрөнгө	545,032,500.00	545,601,979.17
39301	Програм хангамж	1,535,000.00	2,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,452,500.00	-1,543,020.83
39303	Бусад биет бус хөрөнгө	544,950,000.00	544,950,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,914,714,049.89</u>	<u>10,008,163,303.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>379,902.00</u>	<u>436,995,368.18</u>
413	Өглөг	379,902.00	436,995,368.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	379,902.00	424,947,938.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,914,334,147.89</u>	<u>9,571,167,935.35</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	8,914,334,147.89	9,571,167,935.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,532,071,275.49	4,532,071,275.49
51101	Өмч: - төрийн	4,532,071,275.49	4,532,071,275.49
512	Хуримтлагдсан үр дүн	-982,089,817.94	-316,648,916.06
51210	Өмнөх үеийн үр дүн	-982,089,817.94	-973,482,703.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	656,833,787.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,364,352,690.34	5,355,745,575.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,914,714,049.89</u>	<u>10,008,163,303.53</u>

1.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,811,996,795.55	9,399,169,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	853,417,882.79	2,732,777,278.29
120	Нийтлэг татварын бус орлого	191,926,943.79	229,368,445.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	191,926,943.79	223,888,445.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,051,247.00	159,205,435.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,875,696.79	64,683,010.69
120009	Бусад орлого	00.00	5,480,000.00
122	Тусламжийн орлого	661,490,939.00	2,503,408,832.60
122001	Хандив тусламж /дотоод/	661,490,939.00	2,503,408,832.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,958,578,912.76	6,666,392,321.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,842,272,132.46	3,271,334,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,842,272,132.46	3,271,334,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	208,948,880.30	171,127,897.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,565,861.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	195,383,019.30	171,127,897.71
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,907,357,900.00	3,223,929,824.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,907,357,900.00	3,223,929,824.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,994,993,642.06	8,742,335,812.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,994,993,642.06	8,742,335,812.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,991,992,222.85	8,726,403,805.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,038,525,502.00	3,847,639,655.00
210101	Үндсэн цалин	1,636,223,804.00	2,006,319,886.00
210102	Нэмэгдэл	1,199,288,203.00	1,541,468,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,248,500.00	176,257,500.00
210104	Урамшуулал	129,764,995.00	123,593,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,354,328.07	496,230,312.36
210201	Тэтгэврийн даатгал	247,459,941.10	345,585,032.65
210202	Тэтгэмжийн даатгал	31,017,581.75	40,108,499.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,305,265.40	30,855,439.82
210204	Ажилгүйдлийн даатгал	5,751,999.64	7,201,397.59
210205	Эрүүл мэндийн даатгал	57,819,540.18	72,479,942.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	755,373,508.80	908,506,454.82
210301	Гэрэл, цахилгаан	79,276,682.00	97,426,472.82
210302	Түлш, халаалт	542,733,475.00	644,586,530.00
210303	Цэвэр, бохир ус	133,363,351.80	166,493,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,934,137.83	155,508,262.47
210401	Бичиг хэрэг	12,499,995.00	11,724,125.00
210402	Тээвэр, шатахуун	57,727,514.33	57,215,483.74

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,935,307.19	3,484,270.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,803,677.78	16,840,777.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,473,209.00	43,382,334.36
210408	Бараа материал акталсны зардал	23,494,434.53	22,861,271.48
2105	Нормативт зардал	1,474,868,211.38	1,801,740,662.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,360,927,527.38	1,675,321,283.03
210502	Хоол, хүнс	107,882,219.00	120,136,539.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,058,465.00	6,282,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,870,611.95	50,991,765.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	158,400.00	2,723,000.00
210604	Урсгал засвар	67,712,211.95	48,268,765.60
2107	Томилолт, зочны зардал	11,633,675.00	11,827,986.00
210702	Дотоод албан томилолт	11,633,675.00	11,827,986.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,965,079.00	35,745,937.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,520,238.00	4,446,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,722,700.00	7,971,899.60
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,156.00	384,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,712,000.00	8,525,000.00
210807	Газрын төлбөр	293,449.00	1,089,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	80,000.00	50,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,271,536.00	11,856,053.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,467,168.82	1,418,212,769.39
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,100,467,168.82	1,418,212,769.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,001,419.21	15,932,007.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,510,750.00	10,884,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,240,000.00	3,774,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,750.00	7,110,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	490,669.21	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,669.21	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	264.07
213404	Хөрөнгийн	00.00	264.07
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,047,743.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,047,743.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-182,996,846.51	656,833,787.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	77,612,757.72	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	22,884,726.29	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	54,728,031.43	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-77,612,757.72	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-260,609,604.23	656,833,787.46

1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,115,310,418.63	6,830,530,642.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,051,247.00	163,758,419.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,051,247.00	163,758,419.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,051,247.00	158,278,419.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,051,247.00	158,278,419.00
120009	Бусад орлого	00.00	5,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,000,259,171.63	6,666,772,223.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,842,272,132.46	3,271,334,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,842,272,132.46	3,271,334,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,629,139.17	171,507,799.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,565,861.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	237,063,278.17	171,507,799.71
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,907,357,900.00	3,223,929,824.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,907,357,900.00	3,223,929,824.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,075,530,218.63	6,808,532,742.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,075,530,218.63	6,808,532,742.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,072,148,897.42	6,792,600,735.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,040,236,340.66	3,872,001,995.53
210101	Үндсэн цалин	1,650,857,465.00	2,006,319,886.00
210102	Нэмэгдэл	1,186,352,380.66	1,551,847,257.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	73,261,500.00	190,240,972.00
210104	Урамшуулал	129,764,995.00	123,593,880.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,826,207.00	461,243,361.00
210201	Тэтгэврийн даатгал	252,180,100.36	315,100,761.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,958,929.60	36,535,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,250,663.68	29,228,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,325,492.70	7,307,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	53,111,020.66	73,071,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	755,373,508.80	765,182,900.00
210301	Гэрэл, цахилгаан	79,276,682.00	97,426,472.82
210302	Түлш, халаалт	542,733,475.00	550,544,600.00

210303	Цэвэр, бохир ус	133,363,351.80	117,211,827.18
2104	Хангамж, бараа материалын зардал	120,507,660.82	129,025,850.11
210401	Бичиг хэрэг	9,903,900.00	11,406,089.00
210402	Тээвэр, шатахуун	58,587,624.53	55,163,827.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,393,384.19	3,484,270.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,342,920.00	24,614,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,279,832.10	34,356,764.00
2105	Нормативт зардал	1,656,707,574.29	1,443,732,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,529,625,059.29	1,294,995,200.00
210502	Хоол, хүнс	108,752,050.00	119,802,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,330,465.00	28,934,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,894,396.85	71,186,649.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,370,200.00	8,573,800.00
210602	Тавилга	1,748,418.00	3,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	1,031,300.00
210604	Урсгал засвар	63,275,778.85	58,381,549.00
2107	Томилолт, зочны зардал	11,633,675.00	11,827,986.00
210702	Дотоод албан томилолт	11,633,675.00	11,827,986.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,969,534.00	38,399,693.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,381,608.00	4,407,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,722,700.00	7,971,899.60
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	384,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,490,000.00	11,275,000.00
210807	Газрын төлбөр	295,900.00	1,089,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	80,000.00	50,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,626,326.00	11,799,180.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,381,321.21	15,932,007.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,510,750.00	10,884,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,240,000.00	3,774,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,750.00	7,110,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	870,571.21	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	870,571.21	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	264.07
213404	Хөрөнгийн	00.00	264.07
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,047,743.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,047,743.40

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,780,200.00	21,997,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	40,254,809.00	22,691,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,254,809.00	22,691,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,254,809.00	22,691,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,254,809.00	22,691,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-40,254,809.00	-22,691,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-474,609.00	-694,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	474,609.00	1,018,750.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	324,750.00

1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,364,352,690.34	-982,089,817.94	8,914,334,147.89
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,364,352,690.34	-982,089,817.94	8,914,334,147.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,607,114.42	8,607,114.42
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,532,071,275.49	5,364,352,690.34	-973,482,703.52	8,922,941,262.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,607,114.42	00.00	-8,607,114.42
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	656,833,787.46	656,833,787.46
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,532,071,275.49	5,355,745,575.92	-316,648,916.06	9,571,167,935.35

1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,650,380,500.00	6,648,495,099.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,650,380,500.00	6,648,495,099.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,645,300,500.00	6,643,415,099.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,744,759,700.00	3,744,759,700.00
210101	Үндсэн цалин	2,089,948,000.00	2,006,319,886.00
210102	Нэмэгдэл	1,258,264,500.00	1,439,129,081.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	186,417,000.00	176,257,500.00
210104	Урамшуулал	210,130,200.00	123,053,233.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	456,695,600.00	456,695,600.00
210201	Тэтгэврийн даатгал	310,553,000.00	310,553,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	36,535,700.00	36,535,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	29,228,500.00	29,228,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,307,100.00	7,307,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	73,071,300.00	73,071,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	765,182,900.00	765,182,900.00
210301	Гэрэл, цахилгаан	93,130,800.00	97,426,472.82
210302	Түлш, халаалт	550,544,600.00	550,544,600.00
210303	Цэвэр, бохир ус	121,507,500.00	117,211,827.18
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	118,424,200.00	118,424,200.00
210401	Бичиг хэрэг	9,268,300.00	10,092,389.00
210402	Тээвэр, шатахуун	58,201,700.00	55,163,827.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,655,600.00	3,444,270.11
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,864,900.00	21,330,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,433,700.00	28,392,813.89
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	1,440,143,300.00	1,440,128,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,286,899,700.00	1,292,391,200.00
210502	Хоол, хүнс	124,300,000.00	118,802,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,943,600.00	28,934,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,112,500.00	71,112,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,880,500.00	14,373,800.00

210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	1,031,300.00
210604	Урсгал засвар	54,732,000.00	55,707,400.00
2107	Томилолт, зочны зардал	13,500,000.00	11,827,986.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	13,500,000.00	11,827,986.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,482,300.00	35,283,913.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,006,100.00	3,842,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,168,000.00	1,168,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,971,900.00	7,971,899.60
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	384,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,910,000.00	8,910,000.00
210807	Газрын төлбөр	1,089,900.00	1,089,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	70,000.00	50,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,613,400.00	11,613,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,080,000.00	5,080,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,080,000.00	5,080,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,080,000.00	5,080,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,650,380,500.00	6,648,495,099.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,271,334,600.00	3,266,286,856.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,271,334,600.00	3,266,286,856.60
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,223,934,400.00	3,223,929,824.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,223,934,400.00	3,223,929,824.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	155,111,500.00	158,278,419.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,111,500.00	158,278,419.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	231.00	265.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	186.00	219.00
620003	Үйлчлэх ажилтан	42.00	43.00

1.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,201,535.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,201,535.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,007,535.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,242,295.53
210102	Нэмэгдэл	112,718,176.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,983,472.00
210104	Урамшуулал	540,647.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,547,761.00
210201	Тэтгэврийн даатгал	4,547,761.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,473,450.11
210401	Бичиг хэрэг	1,313,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,284,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,835,750.11
2105	Нормативт зардал	3,604,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,604,000.00
210502	Хоол, хүнс	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,054,249.00
210602	Тавилга	12,080,300.00
210604	Урсгал засвар	9,973,949.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,085,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,750,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	185,780.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1194000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,194,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	694,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	171507799.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,507,799.71
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,507,799.71